



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүний
арилжаатай холбоотой зарим журмуудыг
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.3, 9.2.4, 9.2.5, 9.2.6, 9.2.7, 9.2.8, 9.2.11, 15 дугаар зүйлийн 15.3, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-ыг Нэгдүгээр хавсралтаар, "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны төлбөр тооцооны журам"-ыг Хоёрдугаар хавсралтаар, "Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-ыг Гуравдугаар хавсралтаар, "Зэсийн баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-ыг Дөрөвдүгээр хавсралтаар, "Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-ыг Тавдугаар хавсралтаар, "Хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-ыг Зургаадугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан журмуудыг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан журмуудыг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрсөн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаатай холбоотой зарим журмууд шинэчлэн батлагдсантай холбоотойгоор холбогдох этгээдүүдэд танилцуулах сургалт зохион байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн дараах журмуудыг хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:
 - 1) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 19 дугаар тогтоолын Дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам", мөн тогтоолын Тавдугаар хавсралтаар батлагдсан "Нүүрсний арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам";
 - 2) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Зэсийн баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам";

1525010043

- 3) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 31 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам";
- 4) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам".
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР